

**“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 04 сарын 21 өдөр

№ 01

Дархан уул аймаг

“Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023.04.21-ны өдрийн 14⁰⁰ цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд 156158 ширхэг саналын эрхтэй 4 хувьцаа эзэмшигч оролцлоо. Хурлын ирц 95,5 %-тай байгаа нь компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байх тул хурлыг эхлүүлэв. Хурлын даргаар Ж.Очирсүхийг сонгов.

Хурлын дарга: Хурлын дэгийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал болох:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
3. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх
 - а. Ногдол ашгийн ТУЗ-ийн танилцуулга
 - б. бусад

Хурлын дотоод журмын дагуу Санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Д.Бямбажаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг хараат бус гишүүн Д.Чулуун нар танилцуулав.

Хурлын дарга: Эдгээр тайлангуудтай холбоотой асуулт, санал хэлж болно гэв.

Хараат бус гишүүн Д.Чулуун: Санхүүгийн “Пийк Ом Аудит”-тай гэрээ хийж мэргэжлийн зөвлөгөө авч ажиллаж сайн үзүүлэлттэй байгааг сайшааж байна. Ковидтой жилүүдэд ажлын байрыг хадгалж авч үлдэж ажилсаныг, 2022 оноос тогтворжиж ажиллаж байгааг мөн сайн гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч Гүйцэтгэх захирал М.Оюун: Ногдол ашгийн өглөг нь өөр газар оршин суудаг бидэнтэй харьцдаггүй хувьцаа эзэмшигчид байдаг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо энэ мөнгийг Монголын Хөрөнгийн Биржид төвлөрүүлэх шаардлага тавьдаг боловч, зохих бичиг баримттайгаа ирвэл ногдол ашгийг нь өгөхөд бэлэн байна.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Захын дахин төлөвлөлтийг орчин цагийн худалдааны төв ямар байдаг уу, үүнд дахин төлөвлөлтийг уяалдуулан хийе гэж Улаанбаатар хотын Динновишн компани ажилласан. Дараа нь захын үйл ажиллагаа яаж ажиллах вэ гэдэг дээр менежмент хийж ажиллаж байгаа.

Хурлын дарга: Дараагийн хэлэлцэх асуудал Ногдол ашиг олгох тухай. ТУЗ нь хуралдаж ногдол ашиг олгох шийдвэр гаргасан. Үүний дагуу нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ, тараах хугацааг хэлэлцэж шийдвэр гаргана. Гүйцэтгэх захирал М.Оюун: ТУЗ нь хуралдаж ногдол ашиг олгох шийдвэрээ гаргасан. Иймээс нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 300 төгрөгөөр олгоё. Олгох хугацааг 12 сарын 31-ний дотор гэж үзэж байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: Дэмжиж байна.

Хурлын дарга: Өөр санал хүсэлт байхгүй бол санал хураалтаа явуулъя. Тооллогын комисс саналын хуудсаа хувьцаа эзэмшигчдэд тараана уу. Санал хураалт явагдаж дүнг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга Л.Энхсайхан танилцуулж, комиссоос гарах тогтоолоо танилцууллаа.

Хурлын дарга: Тооллогын комиссыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн саналыг гаргахад бэлэн байна. Та бүхэнд танилцуулъя.

Үүнд:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан,
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
3. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх
 - а. Ногдол ашгийн ТУЗ-ийн танилцуулга
 - б. Бусад

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигч та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье.

Хурал 16:00 цагт өндөрлөж байна.

Тэмдэглэл хөтөлсөн:



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
/ Э.Жавхлантөгс /